



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.24 № 288

танай _____-ны № _____-т

**ХАНБОГД СУМЫН ОРГИЛДОРЖШҮГ
ОНӨААТҮГ-Т**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд
заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2022 оны
санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын
тайлан, дүгнэлт, албан шаардлагыг хүргүүлж байна.

Хавсралт 18 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц. ӨСӨХБАЯР



D/Явсан Бичиг/2023он/2023-03-24.Doc

016030208



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: omnugovi@audit.gov.mn

4023.03.15 № 240
танай _____-ны № _____-т

**ХАНБОГД СУМЫН
ОРГИЛДОРЖШҮГ ОНӨААТҮГ-
ЫН ЗАХИРАЛ Ж.ОТГОНДҮҮ
ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ханбогд сумын Оргилдоржшүг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ханбогд сумын Оргилдоржшүг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь барилга хот байгуулалтын газрын дахин төлөвлөлтийн хэмжилтээр 257 га газар нэмэгдэж 3,855.000 мянган төгрөгөөр капиталжуулж үндсэн хөрөнгийн нийт дүн өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй бусад асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

016020334

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 185/А 1643314

Даланзадгад сум

ОМТ - 2023/33/НА-СТА-ОМТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ханбогд сумын "Оргилдоржшүг" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгасан 4,031,968.86 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 75,426,400.48 төгрөгийн бараа материал, 95,095,590.75 төгрөгийн үндсэн хөрөнгөнд тооллого хийж, тооцоо бодоогүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1"үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор", 2/ "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1,2-д заасныг тус тус хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ханбогд сумын Оргилдоржшүг ОНӨААТҮГ-ын захирал (Ж.Отгондүү), нягтлан бодогч (Л.Батзориг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

Т.БУДСҮРЭН

D:\2023он\Явсан Бичиг\Албан шаардлага\2023.03.15 Doc

016040565



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оргилдоржшүг ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2023/33/НА-СТА-ОНА**

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг
2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Аудитор: Т.Будсүрэн
Утас: 70533552 Цахим хаяг: budsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	7
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	7
4. Аудитын тайлан.....	8
4.1 Ерөнхий зүйл	8
4.2 Материаллаг байдал	8
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	9
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
5. Аудитын илрүүлэлт.....	10
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ХАНБОГД СУМЫН
ОРГИЛДОРЖШҮГ ОНӨААТҮГ-
ЫН ЗАХИРАЛ Ж.ОТГОНДҮҮ
ТАНАА

2023.03.15 № 240
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ханбогд сумын Оргилдоржшүг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ханбогд сумын Оргилдоржшүг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь барилга хот байгуулалтын газрын дахин төлөвлөлтийн хэмжилтээр 257 га газар нэмэгдэж 3,855.000 мянган төгрөгөөр капиталжуулж үндсэн хөрөнгийн нийт дүн өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй бусад асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

016020334

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
	Б	1	2
1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	13,826,348.04	6,155,648.73
2	Татвар, НДШ-ын авлага	517,451.55	-
3	Бусад авлага	2,285,456.00	
4	Бараа материал	62,176,628.36	75,426,400.48
5	Эргэлтийн хөрөнгийн дүн	78,805,883.95	81,582,049.21
6	Үндсэн хөрөнгө	2,637,696.74	2,158,541.54
7	Биет бус хөрөнгө	7,543,750.02	11,355,000.00
8	Барилга	88,996.16	86,590.88
9	Тавилга, эд хогшил	851,200.58	584,450.66
10	Компьютер тоног төхөөрөмж	1,697,500.00	1,487,500.00
11	Программ	43,750.02	-
12	Бусад биет бус хөрөнгө	7,500,000.00	11,355,000.00
13	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,181,446.76	13,513,541.54
14	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	88,987,330.71	95,095,590.75
15	Татварын өглөг	175,636.53	4,031,968.86
16	ААНОАТ өглөг	-	620,784.94
17	ХХОАТ өглөг	-	253,015.99
18	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	175,636.53	3,158,167.93
19	Өмч-төрийн	14,503,261.00	18,358,261.00
20	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,780,714.47	4,780,714.47
21	Хуримтлагдсан ашиг	69,527,718.71	75,114,783.21
22	Тайлант үеийн ашиг, алдагдал	-	5,587,064.50
23	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	88,811,694.18	98,253,758.68
24	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	88,987,330.71	95,095,590.75

2.2 Аудит хийсэн ор дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
1	Борлуулалтын орлого/цэвэр/	-	147,846,340.84
2	Борлуулалтын өртөг	-	115,181,431.89
3	Нийт ашиг	-	32,664,908.95
4	Ерөнхий ба удирдлагын зардал	-	26,457,059.51
5	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	-	6,207,849.44
6	Орлогын татварын зардал	-	620,784.94
7	Татвар дараах ашиг /алдагдал/	-	5,587,064.50
8	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	5,587,064.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
1	Мөнгөн орлогын дүн/+/	-	162,630,975.02
2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	162,630,975.02
3	Мөнгөн зарлагын дүн /-/	-	170,301,674.33
4	Ажилчдад төлсөн	-	18,297,325.00
5	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	5,303,070.58
6	Бараа материал худалдан авахад төлсөн	-	144,933,968.50
7	Банкны зардал	-	92,000.00
8	Татварын байгууллагад төлсөн	-	1,675,310.25
9	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(7,670,699.31)
10	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	(7,670,699.31)
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн энхий үлдэгдэл	-	13,826,348.04
12	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,155,648.73

2.4 Аудит хийсэн цэвэр өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	14,503,261.00	4,780,714.47	67,753,000.06	87,036,975.53
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,503,261.00	4,780,714.47	67,753,000.06	87,036,975.53
3	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/			1,774,718.65	1,774,718.65
4	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	14,503,261.00	4,780,714.47	69,527,718.71	88,811,694.18
5	2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	14,503,261.00	4,780,714.47	69,527,718.71	88,811,694.18
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(7,190,136.79)	(7,190,136.79)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,503,261.00	4,780,714.47	62,337,581.92	81,621,557.39
8	Өмчид гарсан өөрчлөлт	3,855,000.00	-	-	3,855,000.00
9	Тайлант үеийн үр дүн	-	-	5,587,064.50	5,587,064.50
10	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	18,358,261.00	4,780,714.47	67,924,646.42	91,063,621.89

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Дугаар	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	-	147,846,340.84
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	115,181,431.89
3	Ажилчдад төлсөн	-	18,297,325.00
4	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	5,303,070.58
5	Бараа материалын худалдан авахад төлсөн	-	144,933,968.50
6	Банкны зардалд	-	92,000.00
7	Татварын байгууллагад төлсөн	-	1,675,310.25
8	Бусад мөнгөн зардал	-	455,125.00

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага үйл ажиллагааныхаа зорилгоо “ард иргэдийг эрүүл аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагаа явуулдаг байгууллага” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, дотооддоо хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оргилдоржшүг ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оргилдоржшүг ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан “Аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.2 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,826,348.04	6,155,648.73	-7,670,699.31
Бараа материал	62,176,628.36	75,426,400.48	13,249,772.12
Үндсэн хөрөнгө	2,637,696.74	2,158,541.54	-479,155.20
Нийт хөрөнгө	88,987,330.71	95,095,590.75	6,108,260.04
ЗГ-ын хувь оролцоо /Эздийн өмч/	88,811,694.18	98,253,758.68	9,442,064.50
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	88,987,330.71	95,095,590.75	6,108,260.04

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна. Бараа материал 13.2 сая төгрөг, үндсэн хөрөнгө 6.1 сая төгрөгөөр өссөн нь газрын м² нэмэгдсэн холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дүгээр зүйлийн 1.2-д заасны дагуу “Оргилдоржшүг” ОНӨААТҮГ-ын захирал Ж.Отгондүү нь зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангаж эдийн засгийн үр дүн, хүрэх түвшинг батлуулсан байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлогоор 147.8 сая төгрөгийг бүрдүүлж, 142.3 сая төгрөгийг зарцуулан, 5.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

4.АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын оргилдоржшүг ОНӨААТҮГ-н 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Будсүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Ж.Болормаа, чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын оргилдоржшүг ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 11-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 164.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 158 мэдээлэл байршуулахаас 30 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"-д заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг үнэн зөв, тогтоосон хугацаанд тогтмол тусгаж байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар Ханбогд сумын оргилдоржшүг ОНӨААТҮГ-ын цалингийн зардал, борлуулалтын орлого, удирдлагын зардал, борлуулсан бүтээгдэхүүний өртөг, цалингийн түүврээр илрүүлсэн илрүүлэлт, бизнес төлөвлөгөө, бодлогын баримт бичиг, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлэн 6 зөвлөмжийн заалтыг асуудлын бүртгэлд тусгасан. Асуудлын бүртгэлээр өгсөн зөвлөмжийн биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1,2 дугаар хавсралтын дагуу “Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгээгүй, си ти эс программ нь аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд уялдаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй, бизнес төлөвлөгөө гаргаж эдийн засгийн үр ашиг тооцож ажиллаагүй, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын цалин болон ажилчдын цалинг ТҮ гэсэн цалингийн

шатлалаар цалинжуулсан, борлуулсан бүтээгдэхүүний өртгийн бүртгэлийг орлогын тайлантай тус тус зөрүүтэй тусгасан байна. Шилэн дансны цахим системд 118 мэдээлэл байршуулахаас 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	Байхгүй.				
Албан шаардлага	Байхгүй.				
Зөвлөмж	6	381,215,194.46	4	198,858,802.53	80
Нийт дүн	6	381,215,194.46	4	198,858,802.53	80

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 381.2 сая төгрөгийн 7 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж, 174.5 сая төгрөгийн 2 алдааг дахин гаргахгүй байх 1 албан шаардлага өглөө.

5.1 Төлбөрийн акт:

Аудитаар төлбөрийн акт гараагүй байна.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Санхүүгийн тайланд тусгасан 4,031,968.86 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 75,426,400.48 төгрөгийн бараа материал, 95,095,590.75 төгрөгийн үндсэн хөрөнгөнд тооллого хийж, тооцоо бодоогүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн "1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор", 2/ "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс" -д заасантай тус тус нийцэхгүй байна.. Зөрчлүүдийг арилгаж ажиллах албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт-1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж-1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдүүлж ажиллах

2. Санхүүгийн тодруулгатай холбоотой асуудал:

Илрүүлэлт-2: Санхүүгийн тодруулга тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1,2 дугаар хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу илэрхийлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС-1, "Санхүүгийн тайлангийн толилуулга"т тус тус хэрэгжээгүй байна.

Өгсөн зөвлөмж-2: Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын дагуу санхүүгийн тайланг илэрхийлэхийг зөвлөж байна.

3. Санхүүгийн программтай холбоотой асуудал:

Илрүүлэлт-3: Си ти эс программ нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд уялдаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11 "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжийг нийтэд мэдээлэх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж-3: Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг 1 дүгээр, "Санхүүгийн тайлангийн А маяг"-ыг 2 дугаар, "Санхүүгийн тайлангийн Б маяг"-ыг 3 дугаар хавсралтаар баталсан заавраар тайлагнахыг зөвлөж байна.

4. Цалинтай холбоотой асуудал:

Илрүүлэлт-4: Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын цалин болон ажилчдын цалинг ТҮ цалингийн шатлалаар цалинжуулсан байна. Засгийн газрын 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, төрийн болон орон нутгийн өмчин тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4/ үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж-4: Төрийн болон орон нутгийн өмчин тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4/ үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

5. Борлуулалтын орлоготой холбоотой асуудал:

Илрүүлэлт-5: Бизнес төлөвлөгөөнөөс борлуулалтын орлогыг 6.3 сая төгрөгөөр биелүүлж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж-5: Орлогын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

6. Шилэн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт-6: Шилэн дансны цахим хуудсанд 158 мэдээлэл байршуулахаас 30 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж-6: Мэдээллийг тогтоосон хугацаанд, шуурхай мэдээлдэг байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	
Дүн	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТ-ны тоо	Тоо	Дүн
Өглөг, авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгөнд тооллого хийгээгүй.	2	174,553,960.09	0	0	1	174,553,960.09	0	0	0	0	0	0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй	1	187,434,056.73	0	0	0	0	1	187,434,056.73	0	0	0	0
Санхүүгийн тодруулга тайланг Сангийн сайдын	1	187,434,056.73	0	0	0	0	1	187,434,056.73	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга		Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
				Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим хуудсанд 158 мэдээлэл байршуулахаас 30 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна		1	0					1	0
Нийт дүн		1	0					1	0